



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/698

Мөрөн сум

Барилга, байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд баригдсан Тэсийн гол, Булнайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны барилгыг байнгын ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал

(Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилга хот
байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ч.Дашдаваа

Г.Ням-Эрдэнэ

(Цэцэрлэг сумын Засаг дарга)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн
дарга)

Д.Аюушжав

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Мэдээлэл харилцаа холбооны хяналтын
улсын байцаагч)

Д.Мягмарсүрэн

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилга техник
хяналтын улсын байцаагч)

Л.Бямбасүрэн

(Аймгийн Онцгой байдлын газрын
Гамшгаас хамгаалах улсын хяналтын
ахлах байцаагч)

Г.Даваадорж

(“Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн ерөнхий
инженер)

Г.Дэлгэрнасан

(Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн
төвийн мэргэжилтэн)

Б.Цэнддэлгэр

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
ахлах мэргэжилтэн)

6712012174

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Ц.Бадмаараг

(“Бадмаараг төсөл” ХХК-ийн архитектор)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

О.Төгөлдөр

(“Энх төгс тэмүүлэл” ХХК-ийн төслийн менежер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Б.Болд

(Тэсийн гол Булнайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны ахлах мэргэжилтэн)

Э.Доржгочоо

(Тэсийн гол Булнайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)


2.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, нийтийн албаны нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл, тайлбарыг гаргаж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж ажиллахыг комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат)-д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Ц.ГАНСҮХ